

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2025/10/22

Дуусах хугацаа: 2025/11/22

Ажил эхлэх хугацаа: 2025/11

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЭРДЭС БАЯЛАГ, БОЛОВСРУУЛАЛТЫН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН БАГШ

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Мэргэжлийн чиглэлийн хичээл заах (Геологи, Эрдэс судлал, Уул уурхайн технологи, Ашигт малтмалын боловсруулалт, Металлурги гэх мэт);
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;
- Төслийн судалгааны ажил болон бакалаврын диплом удирдах;
- МГТИС-ийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.

Тавигдах шаардлага:

- Заах хичээлийн чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй байх;
- Олон улсын их, дээд сургуульд ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно;
- Уул уурхай, үйлдвэрлэлийн програм хангамж ашиглах чадвартай байх;
- Орчин үеийн сургалтын арга зүй болон дижитал технологийг сургалтын үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах чадвартай байх;
- Англи хэлний ярианы болон бичгийн ахисан түвшний чадвартай байх;
- Олон соёлт орчинд ажиллах, харилцах чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл (дээд тал нь 2 хуудас) дээр дурдсан шаардлагуудыг хэрхэн хангаж байгаагаа жишээтэй тайлбарлах;
- Товч намтар (CV);
- Мэргэжлийн болон заах арга зүйн туршлагын талаарх мэдээлэл (дээд тал нь 2 хуудас);
- Цаашид хийх судалгааны ажлын чиглэл, сонирхлыг багтаасан судалгааны ажлын жагсаалт (дээд тал нь 2 хуудас);
- Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт;
- Дээд боловсролын дипломын хуулбар (эх баримт англи хэл дээр биш бол баталгаажсан англи орчуулга хавсаргах)
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захидал.

Холбоо барих:

Та баримт бичгээ англи хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Утас: +976 7023-2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.